

Хэсэг 10

Социализмын дараах Монголчуудын шашин шүтлэг: Бөөгийн шашин

Доржийн Түвшинтөгс

Редакторын тайлбар: Туугий Дорж хэмээн нэрлэгдэж заншсан энэ хүн чин сэтгэлт, ажил хэрэгч Монголын нэгэн бөө билээ. Тэрээр хүн төрөлхтөнд өргөн дэлгэрсэн бөөгийн шүтлэгтэн болохын хамт өөрийн байгуулсан Монголын бөөгийн холбоогоор дамжуулан Монголчуудын өвөг дээдсийн эзотерик бөөг сэргээх зорилго өвөртөлсөн нэгэн юм. Манж Чин улс болон Зөвлөлтийн давамгайлсан социализмын үед бөөгийн соёл алдагдснаас үүдсэн бэрхшээл болон 1990 оноос хойш Монгол дахь бөөгийн сэргэлтийн асуудлуудыг тэрбээр өөрийн илтгэлдээ танилцуулжээ. Өнөөдөр бөө шүтлэг нь хотын олон нийтийн соёлд, мөн хөдөө орон нутагт ч өргөн тархаж байна. Бөө шүтлэг сэргэх явцад бөөгийн хэмээн нэрлэгдсэн бодит бус шүтлэг, зан үйл, мөнгөний төлөөх үйл ажиллагаа болон хувирч, нийгмийн сайн сайхны төлөө хэмээсэн чанараа алдаж буйг Туугий тодруулсан байна. Бүдгэрэн алга болж буй Монголын бөөгийн өвөг дээдсийн соёлын мэдлэгийг сэргээснээр нийгэм, оюун санаа, байгаль орчинтой зохицсон хувь бодгалын санаа бодол бүхий альтернатив бөөгийн ухамсрыг бий болгох ач холбогдолтой ажээ. Туугийгийн өгүүлж буйгаар Монголын бөө нь зурхай, хүрээлэн буй байгаль орчин, газар зүйн соёлын мэдлэг баялагийн өв сан бөгөөд Монголчуудын хувь хүн, нийгмийн харилцааг илэрхийлж байдаг ажээ. Онцгойлон тэмдэглэх нэгэн зүйл бол Туугий Монголчуудын өвөг дээдсээс бөөгөөр дамжуулсан мэдлэгийн хүч, боломжийг шинжлэх ухаан, технологи, сэтгэхүй, баримтжуулах, батлах судалгааг чухалчлан үздэг явдал юм. Ингэснээр Монголын бөөгийн хүмүүнлэг, эерэг боломж нь бүрэн дүүрэн танигдаж, хүн төрөлхтний тусын тулд үйлчилнэ гэдэгт тэрбээр итгэдэг.

Социалист нийгмийн үеийн Монголын шашин шүтлэг нь нийгэм улс төр болон тухайн үеийн улс гүрний хэтийн төлвийн бодлогын улмаас хэт хаалттай, үгүйсгэгдэж, хоригдсон байсан билээ. Мөн нийт ард иргэдийн сэтгэхүйд зориудаар хортой, эсэргүү үйл хэрэг, мунхрал хэмээх ойлголт өгч байсан. Тэр тусмаа Манж Чин гүрний XIX зууны сүүл үеийн бодлогын улмаас бурханы буюу шарын шашны номлолыг Монголчуудад хүртээж, сахил сахиулж, эр хүйстэн бүрийн олонхыг лам болгож, зэвсэг барин тэмцэхийг нь номхотгосон. Мөн уламжлалт бөө мөргөл, тэнгэр шүтлэг, өвөг дээдсийг хүндэтгэх ёсон, андгай тангаргыг дагах сэтгэл, шаардлагатай бол тэнгэрийн зарлигийг гүйцээхээр эвлэлдэн тэмцэх сүлд хийморь, хүч чадлыг нь үгүй хийх бодлогыг явуулснаар олон жилийн туршид энэ бүхэн сулран мартагдсан. Монголын энд тэнд хэсэг бүлэг овог аймгууд бөө мөргөлийг шүтсээр байсан боловч уламжлалт уг үзэл санаа, дэг ёс, мэдлэг мэдээлэл нь мөн л суларч орхигдож байв.

Бичгийн эх сурвалж байдаг боловч уламжлалт нууцыг сахих, дамжуулан үлдээдэг тодорхой бүлэг хүмүүс болон тахилч, тугч, сүлдэч овог, алтан ургийнханд уг бичгийн эх сурвалж өвлөгдөн үлдээгүйгээс бөөгийн шашин бөхөж байв. Зарим нэгэн тэмдэглэл, сурвалжуудад бөө мөргөлийг тодорхойлохдоо:

1. Бөө мөргөлтөн бус хүний нүдээр харж тайлбарласан;
2. Нийгэм болон улс төрийн захиалга, сонирхлын дагуу үндсэн утгыг нь алдагдуулж тэмдэглэсэн;
3. Бурханы буюу шарын шашны сонирхолд нийцүүлэн тодорхойлсон зэрэг шинж чанартай байдаг байна.

Үүний улмаас бөө мөргөл мартагдаж, улмаар сан уншлага бүхий бөө бий болсон. Халх Монголын шарын бөө нар Зонховын шарын шашныг хүлээн авч, хар бөө нараас

илүү эрх мэдэлтэйгээ харуулахыг эрмэлзэж байв.¹ Энэ бүгд суртал, ухуулга, таниулгын дүнд бөө мөргөл нь хэт явцуу хүрээнд тодорхойлогдож, утгын хувьд ихээхэн өөрчлөгдөн хамрах хүрээ нь багассан. Улмаар бөө мөргөл нь зөвхөн жижиг бүс нутгийн хэмжээнд, хэсэг бүлэг овог отгийн дунд л үлдэтлээ мартагдсан. Ингээд социализмын үеийн Монгол улсын үед угаасаа 300-400 жил уламжлал төдий болон үлдээд байсан бөө мөргөл нь тухайн нийгмийн хэлмэгдүүлэлтэнд Бурханы шашны адил өртөж бөө удган хүмүүс баривчлагдаж, хорих ялаар шийтгүүлсэн. Тухайн үед бөө удгад нь өөр өөрсдийн гол усандаа л нутагладаг, эрх мэдэл, эд хөрөнгө, хүмүүс болон нийгэмд үзүүлэх нөлөө нь угаас суларсан байсан учраас бурханы шашны мяндагтан, хутагт хувилгаад шиг амь хохирсон нь цөөн. Гэвч олонх нь 5-10 жилээр хоригдон шийтгэгдэж байсан. Гэхдээ бөө мөргөл нь угаас хэдэн мянганы турш уламжлалт гэрийн сургуулийн аргаар үр хүүхэддээ зааж байсан нь уламжлагдан үлдэж, уг залган бөөлсөн нь одоо би байна. Тэдгээр өв залган ирсэн бөө нараас дор дурдан өгүүлье.

Чөр хэмээх алдарт зайран байсан нь баригдаж 10 жилийн ял аван Сэлэнгэд хугацаагаа дуусгасан. Баригдахын өмнө “юмаа” буцаалаа гээд Үүрийн голд, хэнгэрэг, хуягаа хөвүүлж, толь, сэтэр хуураа авч үлдсэн ч дахин бөөлөөгүй. Үлдсэн толь, сэтэр, хуур нь Эрдэнэт хотод, хүүд (Хуушаан) нь байдаг бөгөөд үр ач нараас нь 2 хүн тодрон уг барьж байгаа. Чой зайран (Чойхүү) Чөр зайрангийн хамт 1 зарлигаар баригдан хоригдсон ба хугацаа дуусаад харих замдаа өвчний улмаас бие барсан. Эд хэрэглэлээ ууланд тавьж толь, хуур, сэтэр, хийморь, хадаг нь үр хүүхдүүдэд нь үлдсэн. Одоо ач зээгээс нь уг барьсан. Мөн Хөх голын соёд Урианхай зайран Лувсандоржийн уг юмыг нь үр хүүхдээс нь бариад удаагүй

¹ Б. Ринчен

байна. Норжмаа удган Эг-Үүлээс уялганд бэр болон ирсэн нэгэн байсан бөгөөд Хосын удганд шавь болон юм заалгаж, дээрхийн хэл болохоор бөөлж байсан боловч баригдан яллагдсан. Хугацаа нь дуусаж гарч ирээд бөөлөөгүй, ойр зууртаа хүн зонд тусалж байгаад жамаараа өөдөлсөн өөрийн төрсөн үр хүүхэдгүй. Одоо дүүгийнх нь хүүхэд уг юмаа барьж, онгод оруулаад 5-6 жил болж байна. Хүүхэнжий удган Дархад нутгийн Уялган, Цагаан-Үүрт мөн бэр болон ирсэн бөгөөд 2009 онд тэнгэрт хальсан. Цагаан-Үүрийн хүн зонд явган бөөлж засал хийдэг, сэтэр татдаг, өвдсөн зовсон хүмүүст тусалдаг хүн байсан. Оросоос нүүж ирсэн буриад хүмүүс Цагаан үүр суманд амьдарч байсан бөгөөд хожим тэдний үр хүүхдүүд нь бурханы номд орж, Дээрхийн хүрээнд шавилсан түүхтэй. Мөн эдгээрийн зэрэгцээ Равжаа гэвшийн үр хойч Удвал удган бөөгийн зан үйлээ сэргээж одоо бөөлж байна. Чандмань-Өндөр сумын Халхын хайрханы Жоовон зайрангийн үр хойч Намжилмаа удган уг юмаа авч бөөлөөд 3 жил болж байна. Энэ мэт социалист нийгмийн үед дарагдмал байдалд мартагдах шахуу байсан бөөгийн шашин нь цаг төрийн тайван байдалд үр хүүхдүүддээ тодорч, сэргэж байна. Гэхдээ дээр дурьдсан бөө удгадын үр хойчсын олонхи нь эцэг эх, өвөг дээдсээсээ шууд мэдлэг авч үлдсэн нь цөөн юм. Тэдний харсан, үзсэн, заримыг нь дамжуулж сонссон нь илүү, зааж зөвлөж багшлах бөө удган ховрын улмаас хуучин байдлаа дахин сэргэхэд учир дутагдал их байна.

Хуучны улсууд, настайчуудаас бөөлж байсан бөө удгадын бөөлөг дэг, ямар онгодод ямар сэтэр татаж, яаж тоходгийг асууж сурч, сэргээсээр байгаа боловч үндсэн голлох мэдлэгүүд нь мартагдсан байна. Эрдэмтэн судлаачдын судалгаа, шинжилгээний материал олдоход бэрх, олдовч тайлбарлан бичихийг оролдсоноос биш бөөлж сурахад дөхөм, нэмэр болох зүйлс ховор байдаг. Тухайн үед онгодоос асууж сурч байсан Тэнгэр, бурхад, уул овооны эздийн нэрс

нь одооны нэрлэгдэж байгаа газар зүй, одон орны нэрнээс зөрөөтэй тул дахин сэргээхэд бэрхшээлтэй байна. Тухайн газар оронд байсан сүм хийдүүдийн номч мэргэдийн тайлбарлаж бичсэн, тахих арга, цаг хугацааг тэмдэглэсэн бичвэр судрууд байгаа боловч мөн бид хүрч үзэх боломжгүй нууцлагдсаар байна. Мөн илэрсэн гаргаж тавьсан зарим бичиг судар нь төвд болон санскрит хэлээр бичигдсэнээс номын хэлнээс хүүрнэл хэл рүү хөрвүүлж өгөх хүн ховор байгаа дараагийн нэг бэрхшээл буй. Өнөөдөр хүн төрөлхтөн, хүүхэд залуучууд мэдлэг мэдээллийг хурдан шуурхай олж авч үнэн, зөвийг нь харьцуулан шинжлэх боломжтой болсон. Энэ нөхцөлд аливаа шашин шүтлэг шаардлагатай зарим мэдээллээс бусдыг нь ил тод болгож, шинжлэх ухаан, ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны баримт нотолгоо, тайлбартайгаар бусдад таниулж, үр хойч, байгаль дэлхийтэйгээ хэрхэн зөв зохистой, харилцан зохиролтой амьдрах замыг олоход тусалж, чиглүүлэх зорилготой орших цаг нь болсон. Уг чанартаа аливаа шашин нь ертөнцийг зүй зохицол, хүн байгалийн зохирохуй, эртний шинжлэх ухаан, амьдралын үнэн ухаанаас ангид байдаггүй гэж би үздэг. Гагцхүү бусдад түгээх, ойлгуулах аргачлал нь өөр өөр байсныг хожим нийгэм, улс төрийн шалтгаанаар бүр бүрхэг болгожээ гэж боддог.

Энэ дундаас бөөгийн шашин нь уг үндэс нь бөгөөд хамгийн ардчилсан, хамгийн шударга, хамгийн шинжлэх ухаанч шашин мөргөл юм. Төр нийгэм нь хэдийгээр хорьж цагдаж, шийтгэж байсан боловч төр, уламжлалаа дээдэлж хүндэлдэг монгол хүн байхын учир утгаа ухамсарлах ухамсарт хүмүүс мэргэд, удирдагч нар Манж Чингийн үед ч, Автономитийн үед ч, социализмын үед ч бөө удганаа бүрэн устгаагүй бөгөөд зарим нэгэн асуудлаа хэлэлцэж зөвлөж байсан баримт байдаг. Тухайн үед бөө удгад нь энгийн ард амьдралтай өөр өөрийн угаас суусан нутаг усандаа амьдарч, зөвхөн шөнө оройн цагаар үйлээ хийж, хүн ардад тусалж, үр

хүүхэддээ эрдэм мэдлэгээ заасаар байсан. Харин үр хүүхдүүд нь бөөгийн дэргэд өсөж, бөөлөхийн эрдмийн ихэнхийг сурч мэдсэн боловч нийгэмшил, ажил хөдөлмөр эрхлэх, хот сууринд суурьшиж амьдарсан болон мөн айж эмээх зэрэг шалтгаанаас үүдэн бөөлөх нь улам багассан.

1924-1930 онд бөө удгад нь чөлөөтэй бөөлдөг байсан ба Улаанбаатар хот орчмын газруудад одоог хүртэл бөө удгадын нэртэй газрууд байдаг. 1930-аад оноос 1950 оны сүүл хүртэл хэлмэгдсэн, хоригдсон, нууцлагдсан боловч хөдөө орон нутгаар бөөлөх зан үйл байсаар байсан. 1960-1980 оны дунд үе хүртэл шинэ үеийн залуус өсөн бойжиж, нийгэмшиж, бөөлөх болон шашны зан үйлийн тухай бусдад мэдэгдэхээс эмээх болсноор уламжлал, мэдлэг нь бүдгэрсэн.

Хэдийгээр Монголын эрдэмтэд 1950-1980 оны хооронд бөө мөргөлийг судалсан, судалгааны суурь, мэдээлэл, эх сурвалж нь хангалттай, бөө удгад нь байсан боловч бичигдсэн эх материал нь тухайн нийгмийн шаардлага, хяналтаас болж зөвхөн дүгнэлт, үгүйсгэл эсвэл домог, угсаатан зүй талаасаа л хадгалагдан үлдсэн өрөөсгөл талтай. Ингээд эцэст нь социализмын үеийн бөөгийн шашин нь шинжлэх ухааны хувьд угсаатны зүй, хэл шинжлэл, үндэстэн ястны зан үйл маягтай, амьдрал дээр зөвхөн нэг нутаг усныхан, төрөл садан зууртаа л нууцаар үйлчилж байдаг хүмүүс болж хувирсан. Харин нийт нийгмийн хувьд хоцрогдсон бүдүүлэг, хууль нийгэм, шинжлэх ухаан, үзэл бодлын эсрэг үзэл суртал маягтай үлдсэн байв.

Социализмын дараах бөө мөргөл

Дээрх байдалтай байсан бөө мөргөл нь 1990 оноос, ардчилал шинэчлэлтийн үеэс дахин сонсогдож, дуулдах болж ард түмэн энэ талаар сонирхож, ярьж сурч эхэлсэн. Эрдэмтэд, бөө удгадын хойч үе “Бөө мөргөл” бөөгийн шашин гэж юу юм бэ гэж эрэл хайгуул хийж, сонирхон судалж эхэлсэн.

Уламжлал ёс заншил, төрт ёс, байгаль дэлхийтэй зохицон амьдрах шаардлага мөн аяндаа тодрон ирж байгаа бөө мөргөлтэй холбоотойгоор эрдэм мэдлэг, уламжлалаа сахин үлдсэн хүмүүсийг олж мэдлэг мэдээллийг цуглуулж, түгээж эхэлсэн.

Ингээд 1995 онд тухайн үедээ орон нутаг болон ард түмэнд танигдсан, уламжлал зан үйлээ гэрийн сургуулиар олж авсан настай, эрдэмтэй, чадалтай бөө удгадаас зөвлөгөө авч, газар цагийг сонгон “Бөөгийн шашны байгууллага” байгуулсан. Энэ нь уламжлалаа, мэдлэгээ бодитой хадгалан үлдсэн сүүлийн цөөхөн бөө удгад, эх сурвалжуудаа мэдлэг ухааныг нь өвлөн авах, тэднийг нэгтгэх боломжийг бий болгосон цаг үеэ олсон маш зөв зүйл байв.

Гэхдээ сөрөг тал бас гарсан нь бөө мөргөлөөр “гоёх”, “ашигчлах”, “гайхуулах”, ид шидийн мэт болгох, эсвэл бүр далдын мэдлэг мэтээр үзэх байдал дагалдан бий болсон. Энэ хандлага үндсэн мэдлэгээ авч үлдсэн хүмүүс нь бурхан болсон 2002 оноос ихэд дэлгэрч, дур мэдэн асар их хийсвэр мэдээллийг гаргаж байна. Ингэснээр бөөгийн шашны үндсэн хэв шинж, уламжлалт дэг ёсыг өөрчилж, хэт бурангуй шүтэх ёс (мухар шүтлэг) гарч эхэлсэн.

Хожмын үеийн бөө нарын олж авч байгаа бичгийн эх сурвалж нь голчлон социализмын үеийн баримт юм. Гэтэл бөө мөргөлийн үндэс нь шинжлэх ухаан бөгөөд үүнд одон орон, байгаль судлал, хүн судлал, тоон ухаан, хөгжмийн ухаан, сүнс, сэтгэл судлал, далд ухамсрын ухааны үндсэн дээр оршдог байтал одоо цагт энэ мэдлэг мэдээлэл нь хэт тасарсан, эсвэл хүмүүсийн сэтгэлд гоёшоох буюу хэт шүтэх үзэл газар авснаар энэхүү чухал утгыг нь алдагдуулж зөвхөн шид чанар буюу ид шид нь хойноос буюу далд сүнс судлахуйг нь голлон барьж төөрөлдөж байна.

Угтаа бөөгийн онгод нь тухайн бөөгийн сэдсэн болон хийх гэж байгаа үйлийн тухай мэдээллийг олж авах гол суваг

байх ёстой бөгөөд юуг юуны хүчээр, хэдийд, хэрхэн хийх аргыг зөв тодорхойлж, хийх үедээ өөрийн хүчээр үр улаачаа хамгаалах холбох, түших үүрэгтэй хий сүнс юм. Жишээ нь бөө хүн Бат гэгч айлын өрх гэрийн гал голомт, хийморь, хэнгэргийг тахиж, Батын заяа тэнгэр (төрсөн орд), сүлд тэнгэр (эрхшээх орд)-ийг олж, гэр өргөөнийх нь голомтыг сахьсан Галын тэнгэр (ус дээдийн овгийн шүтээн)-г олж, эдгээр тэнгэрийг хэдий үед (цаг хугацаа) хаана (орон зай) хэрхэн юугаар (хатуу, зөөлөн арга, бор цагаан идээ) яаж тахихыг мэдэж аваад дараа нь өөрийн онгодоор өөрийгөө мануулж, тухайн голомтын онгодтой холбож бөөлдөг. Харин одоо үед дээр дурдсан шалтгаанаар бөөгийн шашны үндсэн мэдлэг, дэг ёс, уламжлал мартагдсанаар бөө болсон, бөө болгож байгаа хүмүүс бөөгийн шашнаар гоёх, ашиг олох, алдар хөөх зорилгоор бөө болж байна.

Тасарсан эсвэл буруу тайлбарласан эх сурвалжийн тараасан мэдээлэл дээр үндэслэн бөөгийн шашны зөвхөн сүнс онгодын ертөнц буюу хий зүйлд анхаарлаа хэт хандуулж, сүнс онгодын олж гарах тэр л хэмжээний мэдээллээр бөөгийн шашныг ойлгож төсөөлж, сүнсний замбараагүй орчлоос олж авсан шид мэдлэгийн өчүүхэн хэсгийг ихэд бодож төөрөлдөж байна. Зөв замаараа Тэнгэр-Хүн-Газар гурвыг цогцоор нь холбож зөв мэдлэгээр зөв шүтэх аваас бөөгийн шашин нь өнөөгийн бидний хэт техникжсэн, байгалиас холдон тэнцвэр нь алдагдсан дэлхийгээ хэтэрхий оройтохоос нь өмнө хамгаалахад тус болох юм.

Тэнгэр буйд газар буй. Тэнгэр газрын буйд хүмүүн, төр, нийгэм буй. Хүмүүн хийгээд хүмүүнд ухамсар буй цагт онгод буй. Эдгээрийн зүй зохицол, харилцан уялдаа, бие биедээ нөлөөлөх нөлөөллийг танин барьж, амьдрал ахуй, төр улс, дэлхий дахинаа хэрэглэн нийцүүлэхийг Тэнгэр шүтлэг бөө шашин гэнэ.

Одоо тэгэхээр өнөө цагийн бөө мөргөлийн энэхүү

асуудлыг хэрхэн шийдэх вэ? Уламжлалт мэдлэгийг хэрхэн авч үлдэх вэ? Бөөгийн шашны боломж хязгаарыг хэрхэн тайлах вэ?

Мэдлэг мэдээллийг шинжлэх ухааны арга аргачлал, техник технологийн тусламжтайгаар батлах, баталгаажуулах, сорих, боломж бололцоог судлах нь нэг чухал асуудал юм. Эхний шатанд хамгийн тохиромжтой энгийн хүртээмжтэй арга технологиор оюуны төвлөрөл, чадамжийн хэмжээг тодорхойлох хэрэгтэй юм. Техник технологи дээр үндэслэн байж болох үнэмлэхүй жишиг хэмжээ гаргаж тавих хэрэгтэй. Дараагийн шатанд жишиг хэмжээнд хүрч чадаж буй бөө удгануудын онгод буюу сүнс энергийг хураан цуглуулж буй хэр хэмжээ, чадал боломжийг судлах нь зүйтэй. Гуравдугаар шатанд тэнцсэн бөө удгадуудын онгодын болон бөөлөх үедээ нөлөөлж байгааг хэр хүчтэй хэр удаан нөлөө үзүүлж байгааг мөн судлах нь зүйтэй. Үүний дараа бөө нарын тэнгэр, газар, Лус (ус), онгод тахих цаг үе нь одон гариг, цаг улирал, байгаль дэлхийн идэвхжлийн аль үетэй давхцаж, уусан нэгдэж бие биедээ болон үйлчлүүлж байгаа хүмүүст хэрхэн нөлөөлж байгааг судлах шаардлагатай байна.

Аливаа баримт нотолгоонд тулгуурлан эцсийн дүгнэлт гаргадаг ШУ-ы хувьд эцэст нь тултал 100 хувь шинжлэн судалж, нотлох боломж байхгүй боловч тодорхой хэм хэмжээний жишиг гаргаж чадна. Үүний үр дүнд:

1. Дэлхий нийт даяар зөв амьдрахыг хүссэн хүн бүхэнд хэдийд хэрхэн өөрийгөө, өөрийнхөө боломжоор цэнэглэн хүмүүжүүлэх арга замыг нээж өгнө.
2. Бөө мөргөлийн үндсэн шинж, шинжлэх ухааны боломж бололцоо нь дахин сэргэж бусад шашинтай холилдсон, домгийн шинж чанартай болж, мартагдаж байгаа байдал нь үгүй болж цэвэр шинжээрээ хагалагдан өвлөгдөх боломж бүрдэнэ. (Энд бөөгийн шашны далд ухаан, нууц шидийн тухай өгүүлээгүй болно.)
3. Хүн төрөлхтний шинжлэх ухааны мэдлэгт маш том ололт түлхэц болж, байгаль дэлхий хүмүүн хоёрын

зохицлын тухай хамгийн дөт, дөхөм замыг таниулна.

4. Бөө болох боломжгүй, болох ёсгүй хүмүүс хууртагдах, төөрөлдөх, цаг хугацаа, эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирохыг зогсоох алхмууд хийгдэнэ.

Тулгарч буй асуудлууд, түүнийг шийдэх арга зам

Юуны өмнө бидэнд тулгарч буй асуудал нь одон орон, Тэнгэр нарын нэршил,

байр зүг, үүслийн тухай мэдлэг, мэдээллийг сэргээх явдал юм.

Бөөгийн шашны тэнгэр нь:

1. Өөд болсон өвөг дээдэс, хаад ихэс, Монголын цуутай үрсийн сүнс сүлд, онго тахилга;
2. Бөөгийн шашны гол мэдээлэл авах дээд язгуур орчил, орчлон, орон зай, дээд шүтээн;
3. Огторгуйд орших одон гарагс, орд тэнгэрийн эрхсийг тус тусад нь нэрлэдэг ухагдахуун юм.

Дийлэнхи олонхын мэдэж байгаа нь 7 бурхан од, хүн 5 од, марал, мичид 6, алтангадас, үүрийн цолмон, үдшийн гялаан, нар сарны байршил, тахилга, сан өргөл зэрэг юм. Тун цөөхөн хүн (хэсэг бүлэг хүмүүс болон мэдлэг мэдээллийн эх сурвалж нь эртний) 33 хурмаст, 8 гараг, нар сарны тахилга, мөн нэрс, тахих цаг хугацааг нь тоймоор мэддэг. Гэвч зарим тэнгэрийг яг хаана байрлах, хэдийд идэвхижихийг мэдэхгүй байна.

Тэгэхээр үүнээс яаж гарах вэ?

Бид эрэн сурвалжилж, судлах ажлыг эрчимтэй хийж байна. Бөөгийн шашны улбаа тасраагүй, уламжлан ирсэн зах хязгаар нутгаар зорчиж ахмад настан, бөө удган судлаач мэргэдтэй уулзан цулуулах ажлыг өргөн хүрээтэй хийх шаардлагатай байна. Мөн үүний зэрэгцээ харьцуулан дүгнэх аргаар зарим мэдлэгийг сэргээх боломжтой гэж үзэж байна. Үүнд олсон нэрс, байршлыг ШУ-ы нэр томъёо, ойлголттой харьцуулан судалж, тухайн орд, одны идэвхжил, тахилгын хугацаатай давхцаж буйг харуулах боломжтой. Улмаар нийт

Монголын болон Монголчуудын дунд зорчин судалж, жирийн малчин хүний мэддэг тэрхүү нэр томъёо, байр байршил, зүг чиг, үзүүлэх үр нөлөөг ашиглах ухаан, хугацаа тохирлыг тэмдэглэж сэргээх хэрэгтэй байгаа. Энэ бүгдийн нэгдсэн хариу, гаргалгаа байдлыг ШУ-ы боломж бололцооны хэрээр баримтжуулж нийт хүн төрөлхтний мэдлэг, ухаанд хүргэн таниулж арга замыг хайж олох хэрэгтэй.

Бурханы шашны түүх судруудад тэмдэглэсэн нэр томъёог судалж, уламжлан орж ирсэн, авч хэрэглэсэн, мөн хожмын үед Төвд, Санскрит хэл дээр шууд хөрвүүлж буулгасан эх сурвалжтай харьцуулах зэрэг олон талын үйл ажиллагааг авч явуулах шаардлагатай байгаа билээ.

Дүгнэлт

Тэнгэр шүтлэг, бөө мөргөлтэй Монголчууд маань одон гариг, газар зүйн, шид ухаан, арга замын тухай хамгийн эртний, дэлгэрэнгүй, нарийн мэдлэгтэй ард түмэн байсан билээ. Жилийн аль үед лус савдгийн буюу газар усны эрчим, од гаригсын нөлөө илүү байдгийг мэдэж тэрхүү үйлчлэлийг амьдрал ахуй, улс төр, бүхий л ахуйдаа хэрэглэж чаддаг байжээ. Их байвал яаж тахиж өөрсдийгөө хамгаалах, бага байвал яаж, хэдийд тахиж өөрсдөдөө хэрэгтэй болгох вэ гэдгээ бөөгийн шашны мэдлэгээр таньж ашиглан хэрэгжүүлж чаддаг байсан байна. Одоо цагийн бөө нарын мэдлэг нь бичгийн болон аман мэдээлэл дээр үндэслэсэн, дуудлага, дуртгал, зүг чиг нь байгаа боловч чухам яаж гэдэг нь бүрхэг болсон байна. Дээр нь бурханы шашны зан үйл, мэдээлэл, мэдлэгтэй холилдсон. Дийлэнхи олонхи нь дээлэндээ орж байгаа бүрэлдэхүүн хэсгүүдээ нэрлэхээс цааш үүргийг нь тайлбарлаж, өнгө зүс, хэлбэр хийцийн бэлгэдэл чанарыг нь мэдэхгүй байна.